



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 11/079

Улаанбаатар хот

Нийслэлийн хүн амд мэс заслын
тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн
байгууллагуудын үйлчлэх хүрээг шинэчлэн батлах тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.13 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн хүн амд мэс заслын тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудын үйлчлэх хүрээний хуваарийг хавсралтаар баталсугай.
2. Нийслэлийн хүн амд үзүүлэх мэс заслын тусламж, үйлчилгээг нэмэлт төлбөргүйгээр, чанартай үзүүлэхийг хувийн хэвшлийн эмнэлгийн дарга, удирдлагуудад, мэс заслын тусламж үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудтай гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг тогтмол хугацаанд дүгнэж, үр дүнг тооцож ажиллахыг нийслэлийн Эрүүл мэндийн газар /Ш.Энхбат/-т даалгасугай.
3. Хавсралтад заасан хуваарийн дагуу нийслэлийн хүн амд мэс заслын лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлэхийг Улсын нэгдүгээр төв эмнэлэг /Б.Бямбадорж/, Улсын хоёрдугаар төв эмнэлэг /Г.Баясгалан/, Улсын гуравдугаар төв эмнэлэг /Ц.Төмөр-Очир/-т тус тус үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны 75 дугаар тушаал, нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2010 оны А/00 дугаар тушаалыг тус тус хүчингүй болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /А.Эрдэнэтуяа/-д даалгасугай.

САЙД




С.ЛАМБАА

081036

D:\barimt\tushaal

Өрүүл мэнд, спортын сайдын
 2016 оны 7 дугаар сарын 08 өдрийн
 11279 тушаалын хавсралт



Мэс заслын тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудын үйлчлэх хүрээний хуваарь

Тусламж, үйлчилгээний төрөл									
	Баянгол	Баянзүрх	Багануур	Багахангай	Налайх	Сонгино хайрхан	Сүхбаатар	Хан-Уул	Чингэлтэй
Мэс заслын тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага	“Номун” эмнэлэг	Батлан хамгаалах, хууль сахиулах албан хаагчдын нэгдсэн эмнэлэг	Багануур Эрүүл мэндийн төв	Батлан хамгаалах, хууль сахиулах албан хаагчдын нэгдсэн эмнэлэг	Налайх Эрүүл мэндийн төв	“Мөнгөнгүүр” эмнэлэг /7-19, 29-32-р хороо/ “Мишээл” эмнэлэг /1-6, 20-28-р хороо/	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	“Гранд мед” эмнэлэг	“Ачтан” эмнэлэг
Лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага	Улсын гуравдугаар төв эмнэлэг		Улсын нэгдүгээр төв эмнэлэг		Улсын нэгдүгээр төв эмнэлэг	Улсын гуравдугаар төв эмнэлэг		Улсын нэгдүгээр төв эмнэлэг	Улсын хоёрдугаар төв эмнэлэг